



СОЙЕМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№108 /322/

2022.06.10

Цаг үе, үйл явдал

СЭЛЭНГЭ МАРАФОН-2022



Монголын хэт холын гүйлтийн холбоо, Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан Сэлэнгэ марафон-2022 гүйлтийн тэмцээн нь 18-34, 35-49, 50-с дээш насны ангиллаар хагас марафоны төрлөөр энэ сарын 8 өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Уг тэмцээнд 12 аймаг, 9 дүүргийн 530 орчим тамирчид хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдсөнөөс, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны тамирчин хошууч Х.Уянга дасгалжуулагчтай баг

тамирчид амжилттай оролцож, 2 алт, 4 мөнгөн медаль хүртлээ.

Үүнд, эрэгтэйчүүдийн 18-34 нас, 21,095 км-ийн зайд ОУХМ Ц.Бямбажав мөнгөн медаль, 35-49 нас, 21,095 км-ийн зайд спортын мастер Г.Одхүү алтан медаль, спортын мастер А.Бахыт мөнгөн медаль хүртсэн бол эмэгтэйчүүдийн төрөлд 18-34 нас 10 км-ийн зайд спортын дэд мастер З.Ганхишиг мөнгөн медаль, 18-34 нас, 21,095 км-ийн зайд ОУХМ Б.Мөнхзаяа алтан медаль, ОУХМ Г.Хишигсайхан мөнгөн медаль тус тус хүртлээ.

"ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



БНӨСУ-ын Париаг сууринд үүрэг гүйцэтгэж буй 2МБР-ын бие бүрэлдэхүүн орон нутгийн хүүхдүүдийг баярлуулж, "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг хамтдаа тэмдэглэн өнгөрүүллээ.

Париаг суурины эрх чөлөөний талбайд Рувенг засаг захиргааны бүсийн удирдлагууд, засаг дарга, эрүүл мэнд, боловсролын газруудтай хамтарч "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд "Back to school" арга хэмжээг зохион

байгуулж явууллаа.

Тус арга хэмжээний үеэр 2МБР-ын захирагч хошууч Ц.Баатарсүрэн орон нутгийн удирдлага, хүүхэд багачуудад хандан баярын мэндчилгээ хүргэж урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилуулсан юм. Арга хэмжээний төгсгөлд тус суурины 6 бага, дунд сургуулийн төлөөлөлд дэвтэр, бал, харандаа, тоглоом, хүүхдийн хувцас, оньсон тоглоом зэргийг бэлэглэлээ.

Хошууч Ч.БАЯРЖАРГАЛ



"ТЭРБУМ МОД" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ...



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Зэвсэгт Хүчний бүрэлдэхүүн голлох үүрэгтэй оролцож байгаа энэ үед Алтайн өндөр уулсын дунд алба хааж байгаа Уулын тусгай батальон Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн хамт олон дээрх арга хэмжээнд өндөр ач холбогдол өгч, гар бие оролцож аймаг орон нутагт болон ангийн байрлалд мод зүлэг тарих ажлыг идэвхтэй өрнүүлж ажиллалаа. Тухайлбал, ангийн байрлалд 1500 ширхэг хайлаас, 200 ширхэг бургас, 150 ширхэг улиас мод, албан тушаалын 40 айлын орон сууцны цэцгийн мандалд

20 ширхэг мод суулгаж, 0,9 га талбай газрыг зүлэгжүүлээ.

Мөн Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтаж энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн ангийн офицер ахлагчид "Энхийг сахиулагчдын төгөл" байгуулж, 70 ширхэг үхрийн нүд, 85 ширхэг чацаргана тарьж, "Нэг энхийг сахиулагч 3 мод суулгах хөдөлгөөн" өрнүүлэн ажиллав. Түүнчлэн ангийн "Эмэгтэйчүүдийн зөвлөл" ангид хүлэмж байгуулж, өргөст хэмх, улаан лооль, цэцэгт байцаа тарьж, арчлан ургуулж байна.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	☁️ 4


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	☁️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,126.0
EUR 🇪🇺	3,345.0	3,365.0
CNY 🇨🇳	468.00	470.00
RUB 🇷🇺	47.20	48.00
JPY 🇯🇵	23.80	24.30
KRW 🇰🇷	2.51	2.53

ЗУРХАЙ



ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал: Эрхтэн хурц болно
Наран ургах, шингэх: 04.53-20.50

Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй
Суудал: Мод

Энэ өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, лусыг тахиж, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 538,598,656

Эдгэрсэн
Нийт: 511,705,590

Нас барсан
Нийт: 6,327,923

Цахим шууданд

ҮБХИС МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ISO 9001:2015 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА



Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь алсын хараа, эрхэм зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаандаа “Менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандарт”-ыг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2018 онд Стандарт, хэмжил зүйн газраас гэрчилгээ авч, жил бүр магадлах аудит хийлгэж ирсэн.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 03 дугаар сард Стандарт, хэмжил зүйн газраар давтан аудит

хийлгэж, тус газрын дэргэдэх Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын зөвлөлийн энэ оны 5 дугаар дугаар сарын 26-ны өдрийн шийдвэрээр “Менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандарт”-ын гэрчилгээг 2025 оны 5 сарын 26-ны өдрийг хүртэл сунгуулсан. 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Эрдэм шинжилгээний гүйцэтгэл хариуцсан дэд захирал Хурандаа, доктор (Sc.D) профессор, Б.Өлзийхуяг, албаны бусад төлөөллийн хамт Стандарт, хэмжил зүйн газраас

“Менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандарт”-ын гэрчилгээг гардан авлаа. Тус арга хэмжээний үеэр Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг “ҮБХИС нь боловсролын салбарт чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн анхны их сургууль бөгөөд Стандарт, хэмжил зүйн газартай байгуулсан гэрээний дагуу хамтран ажиллаж, байгаад талархал илэрхийлж” бид бүхэнд ажлын амжилт хүссэн юм.

“АХЛАГЧИЙН НЭГ ӨДӨР”-ӨӨР ...



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн “Ахлагчийн зөвлөл”-өөс “Миний гэр бүл” өдөрлөгийг зохион байгуулж явууллаа. Ахлагчийн бүрэлдэхүүний албаны хариуцлага, ёс суртахууныг дээшлүүлэх нөхөрсөг хамт олон болгох, ахлагч нарын гэр бүлд ангийн үйл ажиллагааг сурталчлах зорилготой зохион байгуулагдав. Тус арга хэмжээнд алба хаагчид гэр бүлийн хамт оролцсон бөгөөд “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв” “Насанд хүрэгчдийн боловсролын төв”-тэй хамтран “Хүүхэд хүмүүжүүлэн сургах ухааны өв уламжлал”, “Гэр бүл, халамжит аав” сэдвээр сургалт зохион байгуулсан юм.

Энэ үеэр алба хаагчдын гэр бүлийг ангийн байрлалтай танилцуулан,



жагсаалын болон урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үзүүлэн Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний нийгмийн асуудал сэдвээр яриа өрнүүлж, төгсгөлд нь “Дартс”-ын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд ахлах ахлагч Н.Алтанзулын гэр бүл 1 дүгээр байр, дэд

ахлагч Т.Буяннэмэхийн гэр бүл 2 дугаар байр, ахлах ахлагч Б.Дашнямын гэр бүл 3 дугаар байр эзэлсэн бол ганцаарчилсан төрөлд дэд ахлагч Б.Нордогсүрэн, Д.Долгорсүрэн нар тус тус тэргүүлээ.

Б.ШИНЭЦЭЦЭГ

АРТИЛЛЕРЧИН ДАЙЧИД ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДААР АЯЛАВ



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хугацаат цэргийн алба хаагчдаа байгаль, түүхийн дурсгалт газруудаар аялуулдаг уламжлалтай билээ. Энэ удаа Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхан Танк эсэргүүцэх артиллерийн батарейн хугацаат албаны дайчдаа Чингисийн талбай, Монгол цэргийн музей,

Зайсан толгой, Хүннү молл гэсэн маршрутаар аялуулав. Дайчид Монгол цэргийн дайчин замнал, тэмцэл, ялалтын түүхийг дайчид Монголын цэргийн музейн тайлбарлагч нараас сонсож, зарим эд өлгийн сан хөмрөгтэй танилцахын зэрэгцээ дурсгалын зургаа татуулцаав. Монгол цэргийн музей нь монгол цэргийн түүхийн баримтуудаас гадна хүрэл



зэвсгийн үеийн дайчин уламжлал зэр зэвсгийн түүхэнд холбогдох сумны зэв, хутга, дуулга, ганзагын тогоо “ Хүннү гүрэн”-ний нум сумны зэв, монгол үндэстний сэргэн мандлын дундад зууны аугаа их ялалт, жад, сэлэм, дуулга, хуягаас гадна, их буут цэргийн өвөг алсын зайны харвуур, чөдөр оньс зэргийг дэлгэж тавьснаа дайчдад сонирхуулж байсан юм.

Хошууч Ө.НАРАНТУЯА

ДЭД ТҮРҮҮЧ З.ЭРДЭНЭТСАЙХАН, БАЙЛДАГЧ А.БАНЗРАГЧ НАР АНГИАСАА ШАЛГАРАВ



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Ангийн хугацаат цэргийн алба хаагчдын

мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрын түвшнийг дээшлүүлэх, цэргийн алба хаагчдын харилцан

бэлтгэлжилтийн туршлага солилцох, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор “Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч” шалгаруулах тэмцээний сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатыг ангийн байрлалд энэ сарын 8-ны өдөр явууллаа.

Тэмцээнийг онолын мэдлэг, биеийн тамирын бэлтгэлжилтийн түвшин, нормативын бэлтгэл, скат буудлага гэсэн төрлүүдээр нийт хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгууллаа. Тэмцээнд мотобуудлагын батальоны I ротын I салааны тасгийн захирагч, дэд түрүүч З.Эрдэнэтсайхан, мөн салааны буудагч, байлдагч А.Банзрагч нар бусдыгаа манлайлан дараагийн шатны шалгаруулалтад оролцохоор бэлтгэлд гараад байна.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБА ХААГЧДЫН ХҮҮХДҮҮДЭД “СҮҮЛТ ОДНЫ НУУЦ” МОНГОЛЫН АНХНЫ МӨСӨН ЦИРКИЙН ТОГЛОЛТЫГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Эх үрсийн баярыг тохиолдуулан 90 жилийн түүхтэй Монгол циркийн гайхалтай үзүүлбэрүүдийг мөсөн талбайтай хослуулан бүтээж буй Монголын анхны мөсөн циркийн тоглолт “Мөсөн өргөө” цогцолборт явагдлаа. Монгол цэргийн нэгдсэн холбооноос санаачлан төрийн

цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын хүүхдүүдэд уг тоглолтыг үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээг өнөөдөр амжилттай зохион байгуулж, 9 байгууллагын 300 гаруй хүүхэд хамрагдсан юм. Мөсөн циркийн тайзнаа уран нугаралт; олс дээр явах тэнцвэрийн

үзүүлбэр, жонглёр, агаарын цагариг; дээсээр наадагчид; агаарын нислэг; шидэлттэй банз гэх зэрэг сонирхолтой үзүүлбэрүүд тоглогдсоныг хүүхэд багачууд сонирхон үзэж, гэр бүл, найз нөхөхтэйгөө хамт аз жаргалтай дурсамжтай өдрийг өнгөрөөлөө.

Монгол цэргийн нэгдсэн холбоо